



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/010/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a></p> <p>Цахим актив аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Ж.Ням-Осор Утас: Цахим хаяг: <a href="mailto:tsakhimactive@gmail.com">tsakhimactive@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>4</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>9</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
• Өмнөх үеийн үр дүн дансанд хяналт хэрэгжүүлэх .....	15
• Орлогын дансанд хяналт хэрэгжүүлэх .....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>16</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>17</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ГБХНХС	Гэр бүл хөдөлмөр нийгэм хамгааллын сайд
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 269  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

「НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА Н.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дүүргийн нийгмийн даатгалын газрын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын авлага дансанд үлдэгдэлтэй өмнөх онуудын 56.3 тэрбум төгрөг, тайлант оны 116.6 тэрбум төгрөг, нийт 172.9 тэрбум төгрөгийн авлагыг шийдвэрлүүлэхээр хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын мэдээллийн системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг "Ай Ти Зон" ХХК нь Азийн хөгжлийн банкны төслөөр нэвтрүүлж үндсэн 16 систем, туслах 45 систем, 100 гаруй модуль бүхий нэгдсэн веб суурьтай нэг мэдээллийн сан бүхий Sicos систем рүү шилжүүлсэн бөгөөд энэхүү программаас нийгмийн даатгалын сангийн ерөнхий журнал гарахгүй дутагдалтай байна.

#### Бусад асуудал

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагуудын орон тоог 136-аар бууруулж, цаашид 1341 орон тоотой ажиллах ГБХНХС-ын А/163 тушаал, НДЕГ-ын даргын 2025 оны А/238 тушаалаар тус байгууллагын орон тоог 19 байхаар буюу өмнөх орон тооноос 2-оор бууруулж баталсан байна.

C:\Users\marangua\Desktop\Бичиг хэрэг\2026\010\wdd\wdd\14200\2025\02\2025\_02\_25\_0269\_111.docx 1/26050057

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Т.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,969,353,020.55</b>	<b>5,987,687,927.56</b>
2	<b>1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,745,722,099.72</b>	<b>2,037,515,695.46</b>
3	<b>1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,745,722,099.72</b>	<b>2,037,515,695.46</b>
4	<b>1.1.1.02.01 Төгрөг</b>	<b>1,745,722,099.72</b>	<b>2,037,515,695.46</b>
5	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	1,745,722,099.72	2,037,515,695.46
6	<b>1.1.3 АВЛАГА</b>	<b>2,223,630,920.83</b>	<b>3,950,172,232.10</b>
7	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	407,544,148.09	395,672,826.09
8	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,774,041,655.49	3,477,095,042.62
9	<b>1.1.3.07 Бусад авлага</b>	<b>42,045,117.25</b>	<b>77,404,363.39</b>
10	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	9,241,126.66	5,316,271.53
11	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	32,803,990.59	72,088,091.86
12	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>3,969,353,020.55</b>	<b>5,987,687,927.56</b>
13	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>757,272,045.39</b>	<b>1,254,702,031.01</b>
14	<b>2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>757,272,045.39</b>	<b>1,254,702,031.01</b>
15	<b>2.1.1.03 Өглөг</b>	<b>470,498,883.84</b>	<b>596,795,474.94</b>
16	<b>2.1.1.03.06 Бусад өглөг</b>	<b>470,498,883.84</b>	<b>596,795,474.94</b>
17	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	3,767,674.00	543,909.60
18	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	458,443,096.86	577,467,074.36
19	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	8,288,112.98	18,784,490.98
20	<b>2.1.1.04 Урьдчилж орсон орлого</b>	<b>286,773,161.55</b>	<b>657,906,556.07</b>
21	2.1.1.04.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	286,773,161.55	657,906,556.07
22	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,212,080,975.16</b>	<b>4,732,985,896.55</b>
23	<b>2.2.1 Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,212,080,975.16</b>	<b>4,732,985,896.55</b>
24	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	3,212,080,975.16	4,732,985,896.55
25	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	4,301,483,162.36	3,122,157,065.19
26	<b>2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн</b>	<b>-1,089,402,187.20</b>	<b>1,610,828,831.36</b>
	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>3,969,353,020.55</b>	<b>5,987,687,927.56</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>85,433,815,850.44</b>	<b>98,526,791,603.42</b>
2	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>22,920,922,591.92</b>	<b>27,602,546,452.08</b>
3	1.1.1.02 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	22,920,922,591.92	27,602,546,452.08
4	1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,260,251,102.91	23,100,634,019.44
5	1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	19,260,251,102.91	23,100,634,019.44

Налайх дүүргийн нийгмийн даатгалын газрын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	2,026,356,587.32	2,468,917,505.53
7	1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	968,378,886.64	1,220,524,372.03
8	1.1.1.03.2.0 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	665,936,015.05	812,470,555.08
9	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>92,740,358.22</b>	<b>70,924,245,151.34</b>
10	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	92,740,358.22	159,333,258.34
11	1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	40,832,834.04	49,771,595.16
12	1.1.1.04.1.02.02Бусад хүүгийн орлого	40,832,834.04	49,771,595.16
13	1.1.1.04.1.03 Торгуулийн орлого	6,880,500.00	12,405,750.00
14	1.1.1.04.1.09 Бусад орлого	45,027,024.18	97,155,913.18
15	<b>1.1.1.04.3 Тусламжийн орлого</b>	<b>0.00</b>	<b>70,764,911,893.00</b>
16	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.00	70,764,911,893.00
17	1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив,тусламж	-	25,898,242,978.00
18	1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	0.00	25,898,242,978.00
19	1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	0.00	44,866,668,915.00
20	<b>1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>62,420,152,900.30</b>	<b>0.00</b>
21	1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	22,040,199,600.30	0.00
22	1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,040,199,600.30	0.00
23	<b>1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас</b>	<b>40,379,953,300.00</b>	<b>0.00</b>
24	<b>1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>40,379,953,300.00</b>	<b>0.00</b>
25	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>86,523,218,037.64</b>	<b>96,915,962,772.06</b>
26	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>86,523,218,037.64</b>	<b>96,915,962,772.06</b>
27	<b>1.1.2.01. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,444,800.00</b>	<b>10,336,600.00</b>
28	1.1.2.01.1 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,773,600.00	10,336,600.00
29	1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,378,300.00	6,902,000.00
30	1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,395,300.00	3,434,600.00
31	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	5,671,200.00	-
32	1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	5,671,200.00	-
33	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,504,773,237.64</b>	<b>96,905,626,172.06</b>
34	<b>1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>27,094,675,727.99</b>
35	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	27,094,675,727.99
36	1.1.2.01.4.01.01.5 НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	27,094,675,727.99
37	<b>1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,048,700,802.45</b>	<b>69,810,950,444.07</b>
38	1.1.2.01.4.02.01Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	62,048,700,802.45	69,810,950,444.07
39	1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,456,072,435.19	-
40	1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	24,456,072,435.19	-

41	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,089,402,187.20)	1,610,828,831.36
42	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(1,089,402,187.20)	1,610,828,831.36

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	89,575,972,421.35	103,485,828,714.57
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	27,214,208,670.10	26,274,469,788.38
3	1.1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	27,214,208,670.10	26,274,469,788.38
4	1.1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	18,667,920,723.84	22,022,685,897.98
5	1.1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	18,667,920,723.84	22,022,685,897.98
6	1.1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	1,940,200,068.51	2,342,041,023.45
7	1.1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,015,516,056.78	1,144,918,590.86
8	1.1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	626,445,300.82	764,824,276.09
9	1.1.1.1.03.2.05 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	4,964,126,520.15	0.00
10	1.1.1.1.03.2.05.05 Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	4,964,126,520.15	0.00
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,054,451.25	77,211,358,926.19
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	102,054,451.25	6,434,575,711.19
13	1.1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	40,950,096.51	49,801,894.21
14	1.1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	40,950,096.51	49,801,894.21
15	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	61,104,354.74	6,384,773,816.98
16	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.00	70,776,783,215.00
17	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.00	70,776,783,215.00
18	1.1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	0.00	25,910,114,300.00
19	1.1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	0.00	25,910,114,300.00
20	1.1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	0.00	44,866,668,915.00
21	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,259,709,300.00	0.00
22	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	21,879,756,000.00	0.00
23	1.1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,879,756,000.00	0.00
24	1.1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	40,379,953,300.00	0.00
25	1.1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	40,379,953,300.00	0.00
26	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,311,303,912.45	103,194,035,118.83
27	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	91,311,303,912.45	103,194,035,118.83
28	1.1.1.2.01.БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,096,123.27	20,759,378.15
29	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,773,600.00	10,336,600.00

30	1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,378,300.00	6,902,000.00
31	1.1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,395,300.00	3,434,600.00
32	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	37,322,523.27	10,422,778.15
33	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	37,322,523.27	10,422,778.15
34	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>91,261,207,789.18</b>	<b>103,173,275,740.68</b>
35	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	33,467,508,695.31
36	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	33,467,508,695.31
37	1.1.1.2.01.4.01.01.5 НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	33,467,508,695.31
38	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	61,593,851,916.90	69,705,767,045.37
39	1.1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	61,593,851,916.90	69,705,767,045.37
40	1.1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,667,355,872.28	-
41	1.1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	29,667,355,872.28	-
42	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,735,331,491.10)</b>	<b>291,793,595.74</b>
43	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(1,735,331,491.10)</b>	<b>291,793,595.74</b>
44	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,481,053,590.82</b>	<b>1,745,722,099.72</b>
45	<b>1.3 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,745,722,099.72</b>	<b>2,037,515,695.46</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгөрөгөөр/*

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,387,774,525.26	4,387,774,525.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-86,291,362.90	-86,291,362.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	4,301,483,162.36	4,301,483,162.36
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-1,089,402,187.20	-1,089,402,187.20
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,212,259,175.15	3,212,259,175.15
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	3,212,259,175.15	3,212,259,175.15
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-89,923,909.97	-89,923,909.97
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	3,122,157,065.19	3,122,157,065.19

Налайх дүүргийн нийгмийн даатгалын газрын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Тайлант үеийн үр дүн	-	-	1,610,828,831.36	1,610,828,831.36
15	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,732,985,896.55	4,732,985,896.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	53,034,258,200.00	52,274,819,866.19	52,274,819,866.19	98.57
11	Татварын орлого	27,124,143,900.00	26,364,705,566.19	26,364,705,566.19	97.20
112	Нийгмийн даатгалын орлого	27,124,143,900.00	26,364,705,566.19	26,364,705,566.19	97.20
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,318,754,900.00	22,081,532,006.68	22,081,532,006.68	94.69
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,038,548,200.00	2,344,736,361.13	2,344,736,361.13	115.02
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,002,555,300.00	1,158,764,255.74	1,158,764,255.74	115.58
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	764,285,500.00	779,672,942.64	779,672,942.64	102.01
12	Татварын бус орлого	25,910,114,300.00	25,910,114,300.00	25,910,114,300.00	100.00
122	Тусламжийн орлого	25,910,114,300.00	25,910,114,300.00	25,910,114,300.00	100.00
122001	Хандив тусламж /дотоод/	25,910,114,300.00	25,910,114,300.00	25,910,114,300.00	100.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,669,843,800.00	69,716,103,645.37	69,716,103,645.37	97.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,669,843,800.00	69,716,103,645.37	69,716,103,645.37	97.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,491,300.00	10,336,600.00	10,336,600.00	71.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,491,300.00	10,336,600.00	10,336,600.00	71.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,902,000.00	6,902,000.00	6,902,000.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,589,300.00	3,434,600.00	3,434,600.00	45.26

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 130,143.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 588,263.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 129,555,669.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн 130,143.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

#### 1. Авлага данстай холбоотой

*Илрүүлэлт-1:* Авлагын 129,555,669.1 мянган төгрөгт тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" санхүүгийн тайлан гаргах гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах, цаашид энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Зардал дансыг 182.5 мянган төгрөгөөр бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Программд мэдээлэл оруулахдаа анхан шатны баримт үндэслэн үнэн зөв мэдээлэл оруулах, алдаатай орсон мэдээллийг залруулах процессыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэх зөвлөмж өгөв.

#### 2. Орлого данстай холбоотой

*Илрүүлэлт-1:* Орлого дансыг 405.7 мянган төгрөгөөр бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас

баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэл хөтөлөхдөө анхан шатны баримт үндэслэн үнэн зөв мэдээлэл оруулах, алдааны залруулгыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, Хшилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал данс бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн	1	182.5					1	183.5				
Орлого данс бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн.	1	405.7					1	405.7				
Байгууллагын авлага	1	129,555.7			1	129,555.7						

Налайх дүүргийн нийгмийн даатгалын газрын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дансанд нийт 3,950,172.2 мянган төгрөгийн авлага байгаагаас 129,555.7 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуул аагүй байна.												
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>130,143.9</b>			<b>1</b>	<b>129,555.7</b>	<b>2</b>	<b>589.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн оруулсан ч хугацаа хоцроож байршуулж байна.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/26025004

Улаанбаатар хот

НТАГ-2026/010/НА-СТА-745

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайх дүүргийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар нь авлагын 129,555.669.10 (нэг зуун хорин есөн сая таван зуун тавин таван мянга зургаан зуун жаран есөн төгрөг арван) мөнгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.7."авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллаж, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхыг Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга Н.Өнөржаргал, санхүү бүртгэл, орлого хамралтын хэлтсийн дарга С.Отгонтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

"ЦАХИМ АКТИВ АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Г.НАНДИНЖАРГАЛ

Ж.НЯМ-ОСОР

1426990155